

хорих ял нь тогтмол шинжтэй байсангүй.

В.БАТСАЙХАН

ХСИС-ийн “Гамшиг судлалын төв”-ийн эрхлэгч, доктор /Ph.D/, хошууч

Э.БУЯНТОГТОХ



НОБГ, Аврах гал түймэр унтраах 10 дугаар ангийн орлогч дарга

Д.МӨНХНЯМ



НОБГ, Аврах гал түймэр унтраах 18 дугаар ангийн салаан дарга

**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД
ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБА
ХААГЧДЫН ҮҮРЭГ ОРОЛЦОО**

Хүн төрөлхтөн галыг нээн олж, амьдрал ахуйдаа ашиглаж улмаар хүрэл төмөр боловсруулж, түүхэн хөгжилдөө их үсрэлт хийсэн ч галын ач холбогдлыг эсрэгээр нь хэрэглэж дайсныхаа тариалангийн талбай, хүнсний нөөц, орон байрыг нь галдан шатаах болсноор аюултай зэвсэг болгон хувиргажээ. Гал түймэрт орон гэрээ алдаж, өмссөнтэйгээ хоцрох болсон хүмүүс гэр сууцаа галд тэсвэртэй болгох талаар эрэлхийлж XVI зууны үеэс давсны хүчлийн үйлчлэлийг ашиглан пропетик буюу нэвчилтийг модон материалд хийдэг болсон ба өнөөдөр театрын хөшиг тюль, зөөлөн эдлэлүүдэд галд тэсвэртэй нэвчилтийг

хийсээр байна. XIII-XVI зууны үеийн Монголын эзэнт гүрний байлдан дагуулалтын үед олон мянган хот тосгодоо галдан шатаалгасан Оросын язгууртнууд усны том ган, хувин, царил, хөрөө, сүхтэй морин тэрэг бүхий бяр тэнхээтэй эрчүүдийг нэгтгэн анхны цалинтай гал унтраах нэгжүүдийг байгуулан байнгын бэлэн байдалд байлгадаг байсан тухай түүхэн баримт бичиг ч байдаг.

Эртнээсээ бэлчээрийн мал аж ахуйтай нүүдэлчин манай ард түмэн гал түймэртэй тэмцэх талаар хатуу чанд бодлого баримтлан ирсэн байдаг. 1206 оны Монгол төрийн “Их цааз” бичигт “Ус буюу үнс рүү шээгчийг цаазаар аваачина... Үнсийг хаа хамаагүй асгаж болохгүй, бухын нүх мэт цэвэр газар аваачиж асгана... гэж зааснаас гадна уг цааз бичгийн зүйл 34-д зарлиг зааваргүйгээр эвдлэн, шатаах буюу олзлогсдыг дэвээрээ шийдвэрлэгчдийг алах ялаар шийтгэмой. зүйл 51-д Өвс ногоорсон хойно газар нүхлэсэн ба гал алдаж билчээрийг шатаасны нэгэн гэрийг алмой гэжээ. XVI зууны дунд үед гарсан

Монголын их “Халх журам” хууль цаазын бичгийн IX-р зүйлд галын аюулыг өнөөгийн хэллэгээр “Гал түймэр” гэсэн нэртэйгээр хуульд журамлан тэмдэглэсэн байдаг. “Халх журам”-д Түймэр алдагч өөрөө алдсан түймрээ унтраасан бол, үгүй бол гэх зэргээр торгууль зааж түймэр гарсан бол зар сонссон сонсоогүй унтраах ажилд оролцох иргэний үүргийг тодорхой зааж, зар сонссон байж ноён хүн гал унтраах ажилд эс оролцвол мориор, ямбатан сайдыг бол үхрээр,

энгийн иргэдийг хониор торгож, гал унтраах зар өгсөөр атал ирээгүйг нь тухайн гарын түшмэл өөрийн зэрэг дэвээр баалж, шийтгэх эрхийг нь хүртэл олгосон байдаг нь Ой хээрийн түймэр, ахуйн түймэр гэж үл ялгадаг нэн хатуу чанд хуультай байсныг нь гэрчилнэ. Тэр ч бүү хэл Нүүсэн нутгаас гал гарваас гурван хоногийн нааших болох цааших болохгүй, гэлгүй хэн хүн нүүсэн нутгийнхаа галыг унтраа, эс унтрааваас шүдлэн морь ав гэсэн нь тухайн айл өрх нүүснээс хойш 3 хоног дотор гарсан түймрийг тэднийхтэй хамаатай гэж үздэг байсан нь хариуцлагыг хичнээн өндөрт тавьж ирсэн нь тодорхой юм. Энэ бүгдийг нуршихын учир нь монголчууд гал түймэртэй тэмцэх, түймрээс урьдчилан сэргийлэх талаар ямар уламжлалтайг нь тодруулах гэсэн санаа юм. Найман зууны тэртээгээс улбаатай ийм хуультай Монгол улсад өнөөдөр гал түймрийн аюулаас жил бүр хичнээн хүний алтан амь үрэгдэж, иргэд аж ахуйн нэгж байгууллагын хэдэн арван тэрбумаар хэмжигдэх хөрөнгө үнс болж байгаа нь харамсалтай.

1921 оны 03-р сарын 18-ны өдрийн Хиагт хотыг чөлөөлөх Ардын журамт цэргийн хийсэн тулалдааны дараа Наймаа хотод гал гарч, гал команд байсангүй... бүх хот шатав гэж БНМАУ-н Маршал Х.Чойбалсангийн өгүүлснээр Монголын хувьсгалын түүх номонд тэмдэглэсэн байдаг. 1922 оны 01-р сарын 13 нд Ардын Засгийн Газрын зөвлөх түшмэд нам эвлэлийн гишүүд оролцсон хуралдаанаас гаргасан 35-р хурлын 02-р зүйлд галын аюулаас сэргийлэх газар байгуулахыг

хөхүүлэн баталсан байдаг. Монгол улс түүхэн хөгжлийнхөө дагуу суурин газрууд олноор үүсч, хүмүүс их хэмжээгээр төвлөрөн, суурьшиж засаг захиргааны болоод бусад зориулалтын эмнэлэг, сургууль гэх мэт барилга байшин баригдан өргөжиж дэд бүтэц хөгжсөнөөр гал түймрээс учрах хохирлын хэмжээ өссөөр ирсэн байна.

1925 оны 04 дүгээр сарын 15-нд Оросын худалдааны ахлагч Герченинээс усан хөөргийн газрыг хэрэгсэл ба албан хаагчдын хамтаар эрхэм захиргааны газар шилжүүлэн хүлээн авч, үнийн 2152 доллар 20 центийг төлж гүйцэтгэнэ үү гэснээр Улаанбаатар хотын захиргааны Усан хөөрөгний газрыг байгуулан зардал төсөв, орон тоо, цалин хэрэгслийг Дотоод Яам, Сангийн Яамнаас хянан баталсныг үзвэл ажиллах орон тоо 10, тэдгээрийн сар бүрийн цалин 1100 төг, бичгийн хэрэгсэл 7 төг 49 мөн, хогшил авах зардал 5217 төг, орон байшингийн зардалд 496 төг, морьд бэлтгэхэд 902 төгрөг бүгд 7723 төгрөг 49 мөнгө байжээ. Энэ усан хөөрөг нь одоогийн Дүрслэх урлагийн музейн зүүн талд буюу ХХБ-ны суурин дээр байрлаж байсан. Миний одоо ажиллаж буй 90-н жилийн түүхт Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн “Цэргийн гавьяаны улаан тугийн болон Алтан гадас” одонт гал түймэр унтраах аврах 10-р анги юм. Анх 25 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулдаг усан хөөргийн газар байсан

Дээрх хүснэгтээс харахад галын тоо хохирол тогтмол нэмэгдсээр иржээ. Энэ нь жилд 12-15 хувиар ихэсдэг гэсэн үг

бол өдгөө 117 албан хаагчийн бүтэц бүрэлдэхүүнтэй Онцгой байдлын албаны хэмжээнд урдаа барьдаг нэгж, салбар болон өргөжсөн байна.

Усан хөөргийн газар бий болсон цагаас эхлэн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх талаар төр засгаас анхаарал тавьж ирсний зэрэгцээ хуучин нэрээр ЗХУ-ын Ленинград хотын Галын техникийн дунд сургуульд 1956 оноос, Дээд боловсролтой боловсон хүчнээ Москва хотын Галын инженерийн техникийн дээд сургуульд 1960 оноос эхлэн бэлтгэсэн бөгөөд дунд сургуулийг 240 гаруй техникч, дээд сургуулийг 100 гаруй инженер төгссөн байдаг. 1990 оноос Мэргэжлийн гал сөнөөгч, 1991 оноос галын техникч, 2004 оноос Баклавр зэрэгтэй эрх зүйч - галын ажилтан, 2008 оноос дипломын дээд боловсролтой галын техникч, 2011 оноос Баклаварын дээд боловсролтой Онцгой байдлын байгууллагын ажилтан-эрх зүйчдийг дотооддоо бэлтгэх болсон билээ. Орчин үеийн техникийн дэвшилтэт технологи нэвтэрч өндөр үзүүлэлт, хүчин чадалтай машин техникээр нэг үеэ бодвол хангагдаж ахиц дэвшил гарсаар ирсэн ч гал түймрийн тоо хохирол ямар байгаа талаар Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд сүүлийн 10 жилд объектын ой хээрийн түймэр болон аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын тоон үзүүлэлтээр гаргасан судалгаатай танилцуулья.


юм. Өөр нэг тоон үзүүлэлттэй танилцъя.

2005 онд галд эрсдэгчдийн тоо 43 байсан бол 2011 онд дээд цэгтээ хүрч

амь эрсдэгчэд 142 хүртэл өссөн байна. Сүүлийн 10 жилийн судалгаагаар нийт 784 хүн амь насаа алдаж, 394 иргэн хүнд бөгөөд хүндээр түлэгдсэн нь үнэхээр харамсалтай. Өнөөдөр дэлхийн халуун цэг дээр алба хааж байгаа

ажлын талаарх үзүүлэлттэй танилцъя: Сүүлийн 4 жилээр

Гарсан гал түймрийн зохих хувийг эзэлдэг гэр хорооллын гал түймрийг багасгах талаар зохион явуулдаг ГАУС үзлэг шалгалт 2011 онд 44187 айл



НҮБ-ын цэргүүд ч жилдээ ийм хохирол амсч байгаагүй юм.

Галын аюулаас урьдчилан сэргийлэх

өрхөд үзлэг шалгалт хийж байсан бол 2012 онд 84417 айл өрхийг шалгаж бараг нэг дахин өссөн ч галын тоо



хохирол багасах биш улам нэмэгдсээр л
Захиргааны хариуцлагын тухай
хуулийн 25¹ дүгээр зүйлийн дагуу
торгуулийн арга хэмжээ оноосон
мөнгөн дүн / сая төгрөгөөр / сүүлийн 4
жилд

2011, 2012 оныг бодвол
торгуулийн арга хэмжээ сүүлийн 2
жилд өссөн ч галын тоо хохирол
буурахгүй улам нэмэгдсээр л...

ГАУС ажилд төрөөс төсөвт
хуваарилсан хөрөнгийг 2012 он, 2013
оны байдлаар авч үзье. Гал түймрийн
аюул гарах шалтгаан нөхцөлийг таслан
зогсоох ГАУС асуудлыг нэн тэргүүн
зэрэгт тавих нь зүйтэй гэж үзвэл ОБЕГ-
ын хэмжээнд урьдчилан сэргийлэх
зардал 2012 онд 118,1 сая, 2013 онд
165,3 сая төгрөг зарцуулж байгаа нь
нийт төсвийн дөнгөж 1,9 % -ийг эзэлж
байгаа нь дэндүү чамлалттай.

Үзлэг шалгалт хийсэн, зааварчилгаа,
зөвлөмж өгсөн тоон үзүүлэлт сүүлийн
жилүүдэд тогтмол өссөөр ирсэн байхад
өнөөх галын тоо хохирол буураагүйг
юугаар тайлбарлаж болох вэ? Гадаад
дотоодод сургуулийг нь төгсгөж
мэрэгшсэн ажилтнууд ажиллаж байна.
ГАУС үзлэг шалгалтын тоо жилээс
жилд ахисаар байна. Гэтэл яагаад гэх
тэр асуултын шалтгаан тун энгийн
тодруулбал ГАБТ, ГХТХ маань иргэд,
аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай
авцалдаа муутай хуулийн хэрэгжилтэд
иргэдийн оролцоо, идэвхи туйлын
хангалтгүй байгаагаас гэж болно. 1980-
аад оны эхэн үеэс гэр хорооллоор явж
айл өрхийн галын аюулгүй байдалд
үзлэг хийн санамж, сэрэмжлүүлэг,
заавар, зөвлөмж өгдөг энэ ажил 30

илүү жилийн уламжлалтай ч үр дүн нь
хангалтгүй байгаад дүгнэлт хийж
ГАБТ, ГХТ хуулийнхаа зарим нэг заалт
бүр дээр тогтож дүгнэлт хийхийг
хичээе.

1992 оны 11 сарын 27-нд батлагдсан
Захиргааны хариуцлагын тухай
хуулийн 2 дугаар бүлэг 25¹-р зүйлд
зааснаар “Гал түймэртэй тэмцэх
байгууллагын эрх бүхий ажилтны
хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн,
биелүүлэхээс зайлсхийсэн, гал
түймрээс урьдчилан сэргийлэх
зориулалттай барилгын хийц, бүтэц
болон орон сууцны агааржуулах
төхөөрөмжийг дур мэдэн өөрчилсөн,
галын автомат дохиолол, гал унтраах
тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийг
санаатайгаар гэмтээсэн, тоносон,
түүнчлэн шатах тослох материал,
тэсэрч дэлбэрэх бодисыг зориулалтын
бус газар хадгалах, ой, хээрийн түймэр
тавих зэргээр гал түймрээс урьдчилан
сэргийлэх хууль тогтоомж, эрх бүхий
байгууллагаас тогтоосон журмыг
зөрчсөн нь эрүүгийн хариуцлага
хүлээлгэхээргүй бол зөрчил гаргасан
иргэнийг 1000-50000 төгрөгөөр, албан
тушаалтныг 30000-60000 төгрөгөөр,
байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-
250000 төгрөгөөр торгох шийтгэл
ногдуулна.” гэсэн байдаг. Гэм буруутай
иргэн аж ахуйн нэгжийн удирдлагад
оноох торгуулын шийтгэлээс эхлээд
эргэж харах, өөрчлөлт оруулах,
шинэчлэн сайжруулах зүйл олонтой
харагдаж байна.

ГАБТХ –ийн заалтууд Үндсэн хууль
шиг хөдлөшгүй байдаг юм гэхэд
хуулийг мөрдөх журамд нь тухайн
үеийнхээ мөнгөний бодлоготой

уялдаатай өөрчлөлт оруулах нь нэн ач холбогдолтой гэж үзэж байна. Нэг жишээ авч үзье. Өнөөдөр ГАБ-ын шаардлага хангаагүй ШТС-ын эрхлэгчийг Захиргааны хариуцлагын тухай /1996 оны 05-р сарын 27-ны өдөр хуульд нэмэлт өөрчлөлт орсон./ хуулийн заалтаар 30,000-60,000 төгрөгөөр торгоод яах юм бэ? Өнгөрсөн 9 жилийн хугацаанд төгрөгийн валюттай харьцах ханш хэдэн төгрөгөөр унасан билээ? Энэ нь торгуулийн арга хэмжээ болохгүй харин тохуурхан инээгчийн дансанд хийдэг цайны мөнгө шиг л зүйл болж шүү дээ. Жишээ нь: 1996 оны 01-р сард нэг ам.доллартай харьцах төгрөгийн дундаж албан ханш /Монгол банкны мэдээгээр/ 1\$=475,96 байсан байдаг. Өнөөдөр тэгвэл 2015 оны 01 сард нэг ам.доллартай харьцах төгрөгийн дундаж ханш /Монгол банкны мэдээгээр/ 1\$=1945,25 байгаа эндээс хархад зүй нь торгуулийн мөнгө хэдэн мянган төгрөгөөр өсөх ёстой вэ? Торгуулын арга хэмжээ бол гэм буруутанд төрөөс олгож байгаа халгамаар шийтгэл байж гэмээ нь үр өгөөжөө өгөх учиртай. Иймд торгуулын мөнгөн хэмжээнээс гадна төгрөг валютын харьцааг тогтоосон хувьд байхаар тооцож тусган өгсөн заалт байх юм бол харин гууль биш хууль болж чадна.

Эрүүгийн хуулийн 21-р бүлэг 189 дугаар зүйл: Галын аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчих 189.1. Аж ахуйн нэгж, байгууллагад галын аюулгүй байдлыг хангуулах үүрэг хүлээсэн этгээд галын аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчсөнөөс их хэмжээний

хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

189.2. Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг, онц их хэмжээний хохирол учирсан бол гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Гэсэн заалт байдаг ч улсад үлэмж хэмжээний хохирол учруулсан гал түймрийг санамсар болгоомжгүйгээсээ алдсан гэмт этгээдэд оноосон ялын тухай мэдээлж байсныг би лав сонсоогүй. Энэ талын мэдээлэл байдаггүй нь тус зүйл анги байдаг гэхэд итгэмээргүй санагдахад хүргээд зогсохгүй нохой хуцаж л байдаг юм, жин явж л байдаг юм гэдэгтэй утга нэг болж иргэдийн хариуцлагыг дээшлүүлэх биш харин мартагдахад хүргэж байна. Хэрвээ радио, телевиз, сонин сэтгүүл, интернэт сайтуудаар улсад их хэмжээний хохирол учруулсан этгээдэд оноосон ялын талаар тодорхой мэдээллэдэг бол ард иргэд, албан тушаалтны хариуцлага дээшлэх нь дамжиггүй. Германы нэрт улс төр иргэний уянгын яруу найрагч Курт Тухольский “Улс төр сонирхдоггүй хүн гэж байдаггүй. Яагаад гэвэл хүн гэдэг жараахай нийгэм гэдэг далайд амьдардаг юм.” гэж хэлсэн байдаг. Задлан бодож үзвэл нээрээ л хүн гэдэг жараахай усаа бохирдохоо хүлээгээд зүгээр сууж чадахгүй тул хүссэн хүсээгүй улс төр сонирхох л болно.

Тэгвэл иргэд гэдэг хувийн өмчтөн, аж ахуйн нэгжийн удирдлага хүссэн хүсээгүй заавал сонирхох хэрэглээ болсон ГАБТ, ГХТ хуультай болж чадах л юм бол бидний ажил амжилт олж, ахиц гарна. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгжүүдэд галын аюулгүй байдлыг хариуцдаг хөдөлмөр хамгааллын инженер гэдэг албан тушаалтан байдаг. Байгууллагынхаа хэмжээнд орлогчын мэдэлтэй гэж болохоор энэ албан тушаалтан ГАБТХ-ийн хүрээнд бол зөвхөн зайлшгүй санаж явах жижүүрийн хэдэн санамж хэлж өгчихөөд өглөө бүр нэгдсэн хүснэгт бүхий дэвтэрт гарын үсгийг нь цуглуулж түүгээрээ толгойгоо хамгаалдаг төдий хүн байдаг нь нууц биш. Зүй нь тэр хүн хуулийн өмнө хариуцлага хүлээгч болж байгаагынхаа хувиар азаа үзэгч биш, Мэргэжлийн байгууллагын курс дамжаа төгссөн галын аюулгүй байдлын мэдлэг боловсролтой мэргэжилтэн байх ёстой. Галын аюулгүй байдлын талаар байцаагчийн хэмжээнд бэлтгэгдэхгүй юмаа гэхэд анхан шатны мэдлэгтэй болохгүй юм бол гал түймрийн тоо, хохирол буурахгүйгээр барахгүй, эрдэнэт хүний амь нас хохирсон том хэмжээний галын аюул тасрахгүй ээ. ГАУС ажилд төрийн оролцоо гэдэг нь хуулиар баталгаажсан хугацаатай сургалтад хамрагдаж галын мэргэжлээр төгссөн энэ чиглэлээр ажил хариуцах эрхийг олгосон тодорхой хугацаатайгаар адистатчилагдан эрхээ сунгаж байдаг батламж, диплом, сертификаттай болсон хойноо сая ажил хариуцагч болдог байх тогтолцоотой

болгох шаардлагатай байна. Бас Онцгой байдлын албанд мэргэшсэн албан тушаал эрхэлж байсан буюу тэтгэвэрт гарсан 45-60 хүртэлх насны ажилтанг ч гэсэн ажиллуулдаг байж болох юм. Нөгөөтэйгүүр хариуцлага алдаж хариуцсан объект дээрээ гал түймэр гаргасан Хөдөлмөр Хамгааллын байцаагчийг мэргэжлээрээ ажиллахыг нь учруулсан хохирлынх нь хэмжээгээр 1-3 жил хүртэл эрхийг нь хасдаг ч заалтыг аль нэг холбогдох хуулинд суулгаж өгөх шаардлагатай байна. Хариуцлагын ийм хуульчлагдсан тогтолцоо үгүйлэгдэж байна. Улсын хэмжээний болон салбарын тэргүүний үйлдвэр, аж ахуйн газруудыг тодруулан төрөөс болон салбар зөвлөлөөс шагнал урамшуулал олгодог татварын хөнгөлөлт үзүүлдэг. Тэгвэл тэр урамшууллыг дүгнэх үзүүлэлтэнд ГАБТ, ГХТХуулийн хэрэгжилт уг байгууллага нэгжид ямар байгааг нь хамт дүгнэж, тодруулдаг зарчимд шилжвэл ГАБТ, ГХТХууль бусад хууль тогтоомжтой нягт уялдаатайгаасаа үр дүн нь хамаардаг болгочихвол томоохон ажил болохсон. Нэг жишээ дурдъя: Даатгалын сайн дурын тогтолцоотой байсан авто машин эзэмшигчид “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал”-д хамрагдах болоход багагүй хэл ам болж байсан ч жилийн дараа хэрэглэгчид, хохирогчид байхаа больж даатгалын ач тусыг мэдэрч эхэлмэгцээ 100% гэж болохоор идэвхижсэнтэй адилхан ГАБТ, ГХТ хууль Иргэд, Аж ахуйн нэгж байгууллагад шууд үйлчилдэг болоход бусад хуультай уялдуулсан байдлыг нь төрөөс баталгаажуулаад өгвөл хууль

маань амьд, чанартай, үүргээ биелүүлсэн хууль болох нь гарцаагүй ээ. Солонгосын нэрт бизнесмен Ким Ү Жин “Хорвоо дэлхий уужим хийх ажил их байна” номондоо “Аливаа төсөл, ямар нэгэн байгууламжийн ажлыг эхлэхээсээ өмнө уг ажилдаа шууд хамааралтай байгууллага, иргэдэд энэ төсөл ажил хэрэгжснээр иргэн таны эрүүл мэндэд, ахуй амьдралд, өрхийн төсөвт ийм ийм шинэ нөөц бололцоо нээгдэж цаг хэмнэлт, ашиг орлого, таатай нөхцөл бүрдэнэ гэдгийг үгүй гэж хэлж чадахгүй болтол нь ой ухаанд суулган, хүлээн зөвшөөрүүлж чадвал таны ажил биелэлээ олох магадлал нь төчнөөн хувь нэмэгдэх болно” гэж бичсэн байдаг. Яг түүн шиг ГАБТ, ГХТ хууль таны өмч хөрөнгийг эрсдэлээс хамгаалж тэр хэмжээгээрээ аюулгүй тайван эрүүл орчинд амьдрах бололцоо танд олгогдоно гэдгийг иргэдэд хүлээн зөвшөөрүүлэх үүргийг төр хүлээж холбогдох хуулиудтай нийцсэн орчинг бүрдүүлж хууль тогтоомж эрхийн актуудаар баталгаажуулж, хэрэгтэй байгаа санхүүжилтийг гаргаж өгөх тохиолдолд олон асуудлууд хялбар шийдэгдэх болов уу. Замын цагдаагийн газар сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн дунд “Ногоон гэрэл цагаан шугам” уралдаант тэмцээнийг зохион явуулдаг болоод 30-аад жил болж байна. Дүүргүүдийн хотын аварга шалгаруулдаг энэ тэмцээн тогтмолжиж цэцэрлэг, эцэг эх, хүүхдүүд, мэргэжлийн дэмжлэг үзүүлдэг байгууллага гэсэн холбоо үүссэнээр хүүхдүүд сургуульд ороогүй байхдаа замын хөдөлгөөний анхан шатны танин

мэдэхүйтэй болж гэрэл дохио гарцаар хэрхэн зорчихоо мэддэг болж байгаа нь хамгийн том ололт биш гэж үү? Өнөөдөр Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд болоод ахлах ангийн сурагчид гал түймрийн болон гамшигийн талаар ямар ч ойлголтгүй байна гэж болно. Гамшиг, аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол тэдгээрийн анхан шатны ойлголт, нэр томъёог тэд мэдэхгүй байна. Гамшиг, аюулт үзэгдэл, Техникийн холбогдолтой осол аваарын үед өөрийгөө болон бусдыг аврах дадлага, туршлага тэдэнд олгох мэдлэгтэй багш сурган хүмүүжүүлэгч, хуулийн заалт байхгүй байна. Хэрвээ ЕБС-уудад “Нөхөн үржихүй”-н хичээл ордог шиг сурагчдын сургалтын програмд “Үндсэн хууль”-ийн 2-р бүлэг 16-р зүйлийн 2-т “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэсэн заалтын дагуу “Аюулгүй, эрүүл орчин” гэдэг хичээл ордог байсан бол өнөөдөр хүүхдүүд Гал гаргахын тулд шатах материалд дулааны үйлчлэл үзүүлж хүчилтөрөгчөөр дэмждэг бол галыг унтраахын тулд дулааныг бууруулах үйлчлэлээр ус цацах буюу галыг дэмжигч хүчилтөрөгчөөс тусгаарлан эсгийгээр бүтээх галын хөөсөөр хучих замаар гал түймрийг таслан зогсоож болно. Цахилгааны галыг дулааныг нь бууруулах зарчмаар унтраахын тулд хөлдөөх үйлчлэлтэй галын хор хэрэглэнэ гээд иш онолтой нь шууд хариулах сан. Газар хөдлөлт, үер усны аюул, ахуйн болоод ой хээрийн түймэр хүн малын гоц халдвартай нийгмийг хамарч хурдацтай

тархах хөнөөлт өвчин тахал тэр бүгдээс өөрийгөө болоод бусдыг аврах тусламж үзүүлэх, тусгаарлах зэрэг арга хэмжээний анхны мэдлэгийг ирээдүйн иргэдэд хүргэх хамгийн дөт зам бол яахын аргагүй ЕБС-ийн хичээлийн програмд энэ төрлийн хичээлийг заадаг болох явдал юм. Мэдээж шинээр орон тоо, төсөв хөрөнгө зарцуулах шаардлагатай болно. Онцгой байдлын албанд тангараг өргөсөн аврагч, гал сөнөөгч ахлагч цолтон миний хувьд холбогдох хуулинд нь нэмэлт өөрчлөлт оруулаад сургалтын программд нь “Аюулгүй, эрүүл орчин” сэдвээр хичээл заах болвол харьяа дүүргийнхээ сургуулиудад, хэд хэдэн ангид, олон тооны сурагчдад Гамшиг, аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол зэргийн анхан шатны мэдлэгийг үнэ төлбөргүйгээр, өөрийн санаачлагаар олгох үүрэгтэй гэж би хувьдаа бодож байна. Мөр зэрэгцэн хамт ажиллаж байгаа журмын андууд минь ч над шиг бодолтой байгаа гэдэгт би итгэж байна. Энэ нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангахад бидний оруулах хувь нэмэр юм.

Болзошгүй хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах, үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж, шугам, сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох,

мал, амьтан олноор хорогдох үе тохиолдвол өөртөө болон бусдад үзүүлэх анхан шатны тусламж, нийтийг хамарсан гамшгийн дуут дохиогоор яах ёстойгоо өнөөдөр мэддэг иргэд тийм ч олонгүй гэж болно. Энэ талаар мэдээллийн чанартай сурталчилгаа хийгдэхээс хэтрэхгүй байна.

Болзошгүй гамшигийн үед мянга мянган хүний алтан амийг аварч болох мэдлэг туршлагыг иргэдэд олгох хамгийн оновчтой энэ сургалтыг ЕБС-иар хязгаарлахгүй их дээд сургуулиудад ч хэрэгжүүлэн төгсөгчдийн дипломын дүнд ч нөлөөлхүйц “Үндэсний аюулгүй байдал” гэсэн дүнг бичигддэг болох нь өндөр ач холбогдолтой гэж үзэж байна. Тэгж чадвал хүн амын ихэнх хувийг хүүхэд залуучууд эзлэдэг манай улсын хувьд юутай ч зүйрлэшгүй үр дүн гарах нь мэдээж юм.


ГАБТ хуулийн 4-р бүлэг

22 дугаар зүйл. Гал түймрийн аюулгүй байдлын талаарх мэдээ мэдээлэл 22.1. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гал түймэртэй тэмцэхтэй холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр хэвлэл мэдээллийн хэрэгсэлд дараалал үл харгалзан төлбөртэйгээр нийтэлж нэвтрүүлнэ гэсэн заалтын дагуу “UBS” ТВ-ээр долоо хоног тутамд гардаг Аврагч студийн “Онцгой байдлын цаг” нэвтрүүлэг нь 7 хоногийн ажлын тойм мэдээ төдийгөөр ард иргэдийг уйдаасан, хуучинсаг хэлбэртэй байгаа нь шаардлага хангахгүй байна. Хуулийн дээрх заалт нь шаардлага хангахгүй байгаа тул нийтийн эрх ашгыг хангах, үндэсний


аюулгүй байдалтай холбоотой шинэлэг нэвтрүүлгийг арилжааны болон Монголын үндэсний олон нийтийн радио телевизээр долоо хоног тутамд тусгайлан үнэ төлбөргүй явуулдаг

хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгтэй.

Өргөн уудам нутагтаа тааваараа амьдарч мах сүү, түлээ түлш, унаа хүнс нь гэртээ үйлдвэрлэн амьдарч ирсэн



байхыг цаг үе шаардаж байгаа тул нүүдэлчдийн хэнэггүй тайван зан тал



хээрийн түймэр гарч, газар авахад муугаар нөлөөлж байна.

Хавар намрын хуурайшилттай улиралд Монголын үндэсний радиогоор малчдад “Ой хээрийн түймэр”-ийн үед мал, эд хөрөнгөө аврах мэргэжлийн зөвөлгөө бүхий хичээлийг тогтмол явуулж байвал үр дүнгээ өгөх ач холбогдолтой.

Тогтмолжсон цаг минуттай цацагдах нэвтрүүлгийн сонсогчдийн тоо өснө. Амь бие эд хөрөнгөндөө хайргүй хэн байх билээ. ТВ нэвтрүүлэг нь хүний анхаарал сонирхлыг татах, тэр чанараараа үзэгчидтэй байна гэсэн зах зээлийн бичигдээгүй хууль байдаг. Тэгвэл Онцгой байдлын цаг нэвтрүүлэг нь ярилцлага, номлох, хууль ярихаасаа илүүтэйгээр бодит дүрс бичлэгийг зүрх шимширтэл, тоон үзүүлэлт, судалгаатай үзүүлж байх нь ард иргэдэд түгшүүр төрүүлэхээсээ гадна болгоомжлолыг бий болгоно. Жишээ нь: 1990-ээд оны эхэн үед Дорнод, Сүхбаатар аймагт гарч улс орон даяар дуулиан тарьсан хээрийн түймрийн тухай бүхэл бүтэн баримтат кино байдаг байхад яагаад хавар, намрын хуурайшилттай үеэр Бүх орон нутгийн телевизүүдээр давталттайгаар гаргаж болохгүй гэж. Цаг үе өөр болж интернэт гэдэг цахим ертөнц нээгдснээр асар их бололцоо бидэнд нээгдсэн өнөө үед санаа авмаар, суралцмаар, үзмэгц сэтгэлд нь үүрд хадгалагдахаар дүрс бичлэгтэй нэвтрүүлгүүдийг бэлтгэн түүнийг интернэтийн орчинд цацах боломж байсаар байхад яагаад зохих албан тушаалтан, албадууд хийж хэрэгжүүлэхгүй байна вэ. Миний хувьд

гэхэд интернэтийн орчинд twitter, Facebook зэргээр мэдээ мэдээлэл, мэдлэг боловсрол, сонирхолтой сонин хачин зүйлсийг олж авахын зэрэгцээ өнөөдрийн байдлаар байнгын харьцагч 300-аад залуучуудтай найзлан мэдээ мэдээлэл солилцож байна. Онцгой байдал хэдэн ажилтан албан хаагчтай билээ миний мэдэхээр ЧДОБХ-д twitter, Facebook ашигладаггүй ганц ч албан хаагч байхгүй. Ингэхээр 1 хүний ард 100 иргэн гэж үзвэл 3000 гаруй албан хаагчиддаа үржүүлвэл 300.000 иргэн гэсэн үг үнэ төлбөргүй Гамшиг, галын аюулаас урьдчилан сэргийлэх ажил болж байна. Дээрээс нь сургамжит нэвтрүүлэг, баримтат кино, санамж сэрэмжлүүлэг олонтаа байдаг бол цааш нь түгээн дэлгэрүүлэхсэн. Монголын уран сайхны ‘Хайрлаагүй амь’, ‘МИ-8, ‘Нарны жим” зэрэг кино, Оросын хурдан галт тэргэнд гарсан гал түймрийн тухай, тэнд зорчиж явсан галын ажилтны эр зориг, ариун үйлсийг харуулсан мөн АНУ-ын жижиг хотод усан сан дэлбэлсэн гэмт хэрэгтний гайгаар хотод ямар хүнд байдал үүссэн тухай, 49 шат ‘Солонгосын цамхаг, зэрэг сэтгэл эмзэглүүлсэн гал сөнөөгчийн аж амьдрал, гамшиг ослын дуудлага, түүний хор уршиг зэргийг харуулсан уран сайхны кино, үзвэрүүдийг ТВ нэвтрүүлгийн төгсгөлд уран сайхны кино хэсэгт гаргаж иргэдэд хүргэж байвал гал болон гамшгийн аюулыг нүдээр үзээгүй ахмад буурлууд болон миний үеийн идэр залуучууд, ирээдүйд ихийг хийж бүтээх хүүхэд багачууд маань Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангахад бидний оролцоог болон цаашид авч

хэрэгжүүлэх ажил, урьдчилан сэргийлэх арга хэмжээг чанаржуулахад ахиц гарах боломжтой болно.

Улаанбаатар хотод гарч буй гал түймрийн дуудлагын төрлийг ангилан харуулсан тухайн хүснэгттэй танилцъя.

/Хүснэгт 5, Хүснэгт 6/

Нийслэлийн иргэд хавар, намрын улиралд хашааны хогоо цэвэрлэж шатаах, нийтийн эзэмшлийн гудамж, талбайд ил хог, үнс нурмаа их хэмжээгээр асган хур хогийн цэгийг үүсгэх, өнжмөл өвс шатаах зэрэг иргэдийн буруутай үйлдлээс шалтгаалж гал түймрийн дуудлага ихэссэн байна. Хог шатсан дуудлагыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1100 удаа буюу 33.1 хувиар өсч, энэ нь нийт гамшгийн дуудлагын 35.6 хувийг эзлэж байна. Том оврын ГАМ-ууд 100 километрт хэдэн литр түлш зарцуулдагыг та бүгд мэдэх үү. 40-45 литр. Ингээд бодохоор хогийг шатахгүй байх талаас нь урьдчилан сэргийлэх ажлыг иргэд олон нийт ААНБ-д зохион явуулж чадвал энэ нь төсвийн маш сайн хэмнэлт болно гэсэн үг.

Жишээ нь: Байшин хорооллын хогийн сувгийг авч үзье. Орцны хаалганы хажууд байрлах хогны хуримтлалын өрөөний таазны хэсэгт бидний хэлж заншсанаар шүршүүр суулган өгч, усны шугамтай холбон крантыг нь орцны жижүүрийн өрөөнд байлгах. Гал гарсан үед жижүүр крант онгойлгоно хог унтрана. Нэмээд хэлэхэд СӨХ гэж иргэдээс баахан мөнгө татсан байгууллага байх юм хөрөнгө мөнгийг нь тэндээс шийдчихэж болно.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах үйлсэд өргөсөн тангарагтаа үнэнч шударгаар үүргээ нэр төртэйгөөр гүйцэтгэж байгаа албан хаагчдын нийгмийн асуудлын талаар санал дэвшүүлэхэд: Хийснийхээ хэрээр цалинждаг зах зээлийн шударга үнэлэмжээр нь авч үзвэл Нийслэлийн хэмжээний Гамшиг осол, гал түймрийн дуудлагын 70 гаруй хувьд дангаараа гарч ажилладаг 90 жилийн түүхт Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Монгол Улсын ууган гал унтраах, 1-р зэрэглэлийн “Алтан гадас” одонт Аврах гал унтраах 10 дугаар ангийн алба хаагчид нь Нийслэлийн хэмжээний бүх гал унтраах ангийн алба хаагчидтай адил цалин авч байгааг эргэж харууштай. Энэ талаар судалгаа, шинжилгээ явуулж, үндэслэлтэй гэж үзвэл цалингын шатлалыг нэмэх явдал нь зүйд нийцсэн шударга явдал мөн гэж үзэж байна.

Ашигласан ном, эх сурвалж:

1. Монгол улсын үндсэн хууль;
Галын аюулгүй байдлын тухай хууль;
2. Гамшгаас хамгаалах тухай хууль,
3. Эрүүгийн хууль;
4. Захиргааны хариуцлагын тухай хууль;